



СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А166

Алтанбулаг

“Хором бүрээ анхааръя”- аяныг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дүгээр 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3, 11.2.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Монгол Улсын Их Хурлын 2001 оны 81 дүгээр тогтоолоор батлагдсан Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын 3.1.2, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4, 3.4.1.1, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.2.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Унаж бэртэх, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүн амын мэдлэг хандлагыг өөрчлөн зохистой зан үйлийг төлөвшүүлэх, салбар дундын оролцоог ханган төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, иргэдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэн аюулгүй орчин бүрдүүлэх зорилгоор 2022 оны 11 сарын 15-ны өдрөөс 2022 оны 12 сарын 15-ны өдөр дуустал “Хором бүрээ анхааръя”- сарын аяныг зарласугай.

2. Халтиргаа гулгаа, унаж бэртэх, осолт хөлдөлтөөс урьдчилан сэргийлэх аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр цахим мэдээлэл сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, иргэдэд сэрэмжлүүлэг, сургалт, мэдээлэл хүргэх зохион байгуулах ажлыг нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлд үүрэг болгосугай.

3. Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн аюулгүй байдлыг бүрдүүлж, халтиргаа гулгаанаас сэргийлэх ойр орчмын цас, мөсийг цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт хариуцуулсугай.

4. Замын халтиргаа гулгаанаас сэргийлэх аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол гэмтлээс сэргийлэх ажлыг зохион байгуулахыг Засаг даргын орлогч (Х.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж холбогдох газар хийсэн ажлын тайланг нэгтгэж хүргүүлэхийг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Мөнхзул)-д даалгасугай.



Н.ОТГОНЦОГТ